

ОРЧИН ҮЕИЙН ТӨВ АЗИЙН МАЛ АЖ АХУЙ

М.Хурметхан*

Төв Ази гэдэг ойлголтонд газарзүйн нэгдмэл байдал, нутаг дэвсгэр, хүн ам, ижил төстэй тал нь ялгаанаас давуу байгаа, соёл иргэншил түүхийн хувьд ойр дөт байдал, ургамал-амьтны аймгийн ерөнхий төлөв, нийгэм-эдийн засгийн байдлыг харгалзан үзвэл зохих билээ. Өнөөгийн ойлголтээр газарзүйн хувьд авч үзвэл, Казахстан, Киргизстан, Өзбекстан, Таджикстан, Афганистан, Монгол Улс, ОХУ-ын субъектууд болох Буриад, Тыва, Алтайн ЕНУ, БНХАУ-ын ӨЗО болох Синьцзян, Өвөрмонгол, Төвдийг оруулсан байдаг юм.

Төв Ази гэдэг ойлголт нь Азийн энэ хэсэгт зориулсан Германы нэрт газарзүйч, байгаль судлаач эрдэмтэн А.Гумбольдтын сонгодог бүтээлийн ачаар 19-р зууны хоёрдугаар хагаст шинжлэх ухааны хэллэгт орж ирэв. А.Гумбольдт уртрагаар Тураны нам тал ба Их Хянганы нурууны хооронд, өргөжгөөр Алтайн нуруу, Гималайн нурууны хоорондох өндөрлөг бэлэнцэг-уулархаг нутгийг Төв Ази гэж нэрлэсэн байна. Хожим нэрт байгаль судлаач Ф.Рихтгофен геологийн эрт биш үед далайтай холбоогүй болсон Арал ба Каспийн ай савыг оруулаагүй Азийн далайд урсгалгүй мужийг Төв Ази гэж нэрлэхийг санал болгожээ. Төв Ази нь амьтны газарзүй, геоботаник, хөрс, уур амьсгал, геоморфологи, уулзүйн зэрэг чухал онцлогуудтай ба ландшафтын өвөрмөц хэв шинж нь түүнийг хүрээлсэн мужуудаас эрс ялгаж өгсөн байдаг¹. Өөрөөр хэлбэл, хойд өргөргийн 39.5 хэм ба 49.5 хэмийн хооронд Каспийн тэнгисээс Их Хянганы нуруу хүртэл орон зайг Төв Азид оруулсан анхны тодорхойлолтыг А.Гумбольдт өгсөн байна.

Төв Азийн ОХУ-ын сектор - Өмнөд Сибирийн уулс орно. Өмнөд Сибирийн уулс нь 1.5 сая км талбайтай томоохон уулархаг нутгийн нэг юм. Өмнөд Сибирийн уулархаг мужид Алтай, Кузнецкийн Алатау ба Салаир, Саян, Тыва, Байгаль орчим, Өвөр Байгаль, Становын нуруу багтдаг. Уулархаг орны нутагт Буриад, Тыва, Алтайн БНУ, Чита муж бүтнээр, Кемров, Красноярск ба Алтайн хязгаар, Новосибирск, Эрхүү муж, Якутын БНУ-ын зарим хэсэг багтана. Өмнөд Сибирийн уулархаг мужийн хилийн дундаж хур тунадас 300-400 мм юм. Хамгийн дулаан 7 сарын дундаж температур нь +19 градус бөгөөд хамгийн хүйтэн 1 сарын дундаж температур нь -20 градус байдаг. Энд бүх нутгийн 70%-д цэвдэгт хөрс чулуулаг тархсан байна.

* М.Хурметхан – ОУСХ-гийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан доктор (Sc.D), Профессор

ОХУ-ын Төв Азийн сектор. Хүснэгт № 1/Малый Атлас СССР.М.1980/

№	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь	Талбай \мян. км.кв\	Хүн ам \сая\
1.	Буриад БНУ	351.5	1
2.	Тыва БНУ	170.5	0.3
3.	Алтайн хязгаар үүнээс: Алтайн БНУ	261.7 12.9	2.7 0.2
4.	Чита	431.5	1.3
5.	Кемеров	95.5	3
6.	Эрхүү мужийн баруун өмнөд хагас	400	2.6
7.	Хакас БНУ	61.9	0.6
8.	Красноярскийн хязгаарын өмнөд хэсэг	140	3.2
9.	Төв Азийн ОХУ-ын сектор	1817	14.7

Төв Азийн БНХАУ-ын сектор - БНХАУ-ын нутаг нь 3 үндсэн физик газарзүйн мужид хуваагдаж, үүний хоёр нь Төв Азид багтдаг.

Баруун хойд хуурай район: БНХАУ-ын нутгийн 30%-ийг эзэлж, тариалангийн 10%, хүн амын 4% суудаг. Хуурай, хагас хуурай, эх газрын уур амьсгал тод илэрсэн, үндсэндээ бэлчээр гэж үздэг цөл, цөлөрхөг хээр ба хээрийн ургамалшилтай юм. Ихэнх голууд нь гадагш урсгалгүй дотоодын ай савд багтдаг. Дунджаар далайн түвшнээс дээш 1000-1500 м өндөрт оршино.

Хүйтэг Альпийн Хөх нуур-Төвдийн район: БНХАУ-ын нутаг дэвсгэрийн 25%-ийг эзэлж, тариалангийн 0.8%, хүн амын 0.8% оршиж, дунджаар далайн түвшнээс 4000м өргөгдсөн. Энд мөстлөг, мөсөн гол бүхий 5000-8000м өндөр ер бусын өндөр уулс оршино. Мужийн ихэнх гол гадагш урсгалгүй дотоодын ай савд багтдаг. Үндсэндээ цөл, хээр, нуга ба бут сөөгөрхөг хэв шинжийн ургамалшилтай. БНХАУ-ын Төв Азийн секторт бэлчээр нуга-319.3 сая га, цөл сэвсүүл, элсэн доорх газар-101.3 сая га, байнгын цастай газар, мөсөн гол-4.7 сая га, өвслөг гүвээ ба хажуу-101.3 сая эзэлнэ².

БНХАУ-ын Төв Азийн сектор, хүснэгт № 2 /Энциклопедия нового Китая. М.,1989.с.16/

№	Мужийн нэр	Талбай \мян.кв.км\	Хүн ам/сая/
1	Хөх нуур \Цинхай\	720	4.07
2	Өвөрмөнгөл	1183	20.07
3	Ганьсу	450	20.41
4	Синьцязн-Уйгур	1600	13.61
5	Төвд	1220	1.99
	Төв Азийн БНХАУ-ын сектор	5173	60.1

Төв Азийн баруун хэсэг Казахстан, Дундад Ази нь халуун хуурай зунтай, өвөл нь цас бага унадаг, харьцангуй хүйтэн өвөлтэй, эх газрын уур амьсгалтай бүс юм. 7-р сарын дундаж температур нь +25 градус, харин 1-р сарын дундаж температур -15 градус орчим байна.

Төв Азийн тусгаар тогтносон БНУ-уд /хүснэгт № 3/

№	Улсын нэр	Талбай /мян.км.кв/	Хүн ам /сая/\ /
1	Казахстан	2715.1	17.3
2	Өзбекстан	449.6	21.3
3	Туркменстан	488.1	4.6
4	Киргизстан	198.5	4.5
5	Тажикстан	143.1	6
	Төв Азийн БНУ	3994.4	53.7

Монгол Улс нь Төв Азийн бүс нутгийн зүүн хэсэгт, Ази тивийн зүрхэн талаар орших өвөрмөц газарзүйн байрлалтай. Баруунаа Монгол Алтайн нурууны Таван богд уулнаас зүүн тийш Их Хянганы нурууны Соёлз уулс хүртэл 2300 орчим км урт, хойд талдаа Соёны нурууны Монгол шарын даваанаас урагш Орвог гашууны бор толгой хүртэл 1200 гаруй км үргэлжлэх 1564.4 мян.кв.км нутаг дэвсгэртэй. Монгол улсын нутаг үндсэндээ уулархаг бөгөөд хамгийн нам цэг нь далайн түвшнээс 560м өргөгдсөн Их нууруудын хотгор юм. Хагас хуурай уур амьсгалтай, хойд хэсгийн Хөвсгөл, Хангай, Хэнтийн нурууны орчимд ой, тайга бүхий олон гол мөрөн бүхий усан сүлжээтэй. Жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 200-220 мм болно. Монгол орны нутаг дэвсгэрийн 60 орчим хувьд цэвдэгт хөрс чулуулаг тархжээ. Харин хэв шинжийн хувьд тундр-царамын уулын нугын ба нугат хээрийн, уулын хуурай хээрийн, ой тайгын, хар шороон, хүрэн хөрс, бор хөрс зэрэг юм.

Төв Азийн бүс нутаг /хүснэгт № 4/

№	Төв Азийн секторууд	Талбай /мян.кв.км/	Төв Азийн нутагт эзлэх %	Хүн ам /сая\	Төв Азид эзлэх %	Хүн амын нягт хүн/км ²
1	Монгол Улс	1564.4	12%	2.4	1.8%	1.5
2	Казахстан, Дундад Азийн 4 улс	3994.4	31%	53.7	41%	13.4
3	БНХАУ-ын сектор	5173	42%	60.1	46%	11.6
4	ОХУ-ын сектор	1817	14%	14.7	11.2%	8.2
	Төв Ази	12548.8	100%	130.9	100%	10.4

Төв Азид бүс нутгийн 6 улс, улс төрийн хувьд тусгаар тогтносон нь бүс нутгийн 43%-ийг эзэлж, харин 56% нь ОХУ, БНХАУ-ын дотоод муж байдлаар оршин тогтнож байна. Төв Ази нь дэлхийн хуурай газрын 23%-ийг эзэлнэ. Төв Ази нь зөвхөн физик газарзүйн мужлалтыг төдийгүй эрхлэх аж ахуйг /бэлчээрийн мал аж ахуй/, түүх соёл, угсаатны зүй, улс төрийн засаглалыг багтаасан нийгэм эдийн засгийн нийлмэл бүс нутаг болно. Ялангуяа, энэ мал аж ахуйгаас тод томруун харагдана. Төв Ази бол дэлхийн хамгийн удам бэлчээртэй бүс нутаг болно. Гэхдээ бэлчээрийн даацын хувьд хамгийн сайн нь биш. Төвд-Хөх нуурын өндөрлөг бол дэлхийн хамгийн өндөрлөг нутаг төдийгүй 12.3 сая сарлаг бүхий хамгийн сайн бэлчээр юм.

Төв Азийн бэлчээр /хүснэгт № 5/

№	Улс	Бэлчээр /сая.га/	Нийт талбайд бэлчээрийн эзлэх хувь	Цэвдэгт хөрсийн эзлэх хувь
1	Монгол Улс	125	79.9%	60%
2	Казахстан ДА-ны 4 БНУ	213.4	53.4%	5%
3	Төв Азийн БНХАУ-ын сектор	310	59.6%	35%
4	Төв Азийн ОХУ-ын сектор	25.4	15.5%	90%
	Төв Ази	676.8	53.9%	34%

Төв Азид 13 сая илүү сарлаг өсгөн үржүүлдгийн 5% нь Монгол Улсад, 94% нь БНХАУ-ын Төв Азийн секторт байна. Мөн Төв Азийн гандуу уулархаг нутгийн ямааны аж ахуй, дэлхийн ноолуурын 90%-ийг /Монгол Улс 30%, БНХАУ 60%/ өгдөг бүс нутаг юм. Төв Азийн БНХАУ-ын сектор нь тус улсын мал аж ахуйч бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гол бүс нутаг юм.

Төв Ази нь олон хүчин зүйлийн, тухайлбал, эдийн засаг, соёл иргэншил, тээврийн гол зангилаа газар болдог нь түүний дэлхий дахины ач холбогдлыг бий болгож байдаг. Төв Ази нь нүүдлийн соёл иргэншлийн өлгий нутаг юм. Тэгээд ч соёл иргэншилд нь нүүдлийн мал аж ахуйн ач холбогдол их билээ.

Төв Азийн таван хошуу мал, түүний онцлог

Адууг сүрэг. Төв Азийн нүүдэлчдийн таван хошуу малын³ нэг нь адуу юм. Тэд адуугаа мал сүргийн манлай хэмээн хүндэлдэг. Адууг ачаа даах, унааны эдэлгээ, сүү сааль, махыг ашиглана. Мах нь маш чанартай, айраг нь эмчилгээний чухал ач холбогдолтой.

Адууны үүсэл: 50 сая жилийн тэртээ дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын дулаавтар уур амьсгалтай, ус чийг ихтэй ой хөвчид үнэгийн чинээхэн биетэй зогиппус хэмээх амьтан амьдарч байсан нь адууны өвөг байжээ. Цаашдаа тэр

амьтны дүрс нь өөрчлөгдөн томорсоор 3 хуруутай мерикгиппус, бүр сүүлдээ одоогийн адуутай төстэй битүү туурайтай хэд хэдэн салбар адгуус болон хувирчээ. Төв Азид зэрлэгээр оршдог тахь буюу Пржевальскийн адуунаас одоогийн мэнгол адуу үүссэн гэж үздэг. Улмаар хүрэл зэвсгийн үед Европт нутагшсан байна. Адууг гаршуулсан нь Төв Азид барагцаалбал МЭӨ 2-1-р мянган жилийн өмнө юм. Адуу нь ачааны /владимир г.м/, хөллөх /орлов, орос, американ/, уналга /араб, акалтек. г.м\, тал хээрийн /дон, буденный, монгол, казах г.м/, уулын //кабродин, харабах, киргиз, алтай, азербайжан/, ойт хээрийн /вятка,эстон, якут г.м\ 200 орчим болж салбарласан байдаг. Төв Азийн нүүдэлчид дээр үеэс адууг сурган ашигласаар иржээ.

Адууны ашиг шим: Адуунаас сүү сааль, мах, арьс шир, хөөвөр хялгасыг авч ашиглахаас гадна адууг уналга эдэлгээнд өргөн ашиглана. Сүү сааль: Унагатай гүүг 4-6 сарын хугацаагаар барьж, өдөр 6-8 удаа сааж, нэг гүүнээс дунджаар өдөрт 3л сүү авна. Гүүний сүү бол хүний бие махбодод хялбархан шингэдэг уураг, чихэрлэг эрдэс бодис, төрөл бүрийн витамин, ялангуяа С витаминаар баялаг юм. Сүүгээр нь айраг эсгэнэ. Төв Азийн нүүдэлчдээс Монгол, Казах, Киргизууд адууны сүүг их хэмжээгээр хэрэглэдэг юм. Тэд айраг бэлтгэх өвөрмөц технологийг эзэмшсэн байдаг. Казахуудын айраг бэлтгэх технологийн талаар “Кумыз, Шубат” /А,1979/ хэмээх номонд тодорхой судлан өгүүлжээ.

Мах: Төв Азийн адуу, ялангуяа, монгол, казах адууны мах нь амт чанартай. Судалгаанаас үзэхэд нас гүйцсэн адуу 280-320 кг амьдын жинтэй, 76%-ийн цэвэр мах, өөхийн гарцтай. Адууны мах бусад малынхаас илчлэгээр дутуугүй, уургаар баялаг, идэхэд шингэц сайтай. Казах үндэстний хоол хүнс, заншилд адууны мах тэргүүн үүрэг гүйцэтгэнэ⁴.

Арьс шир: Адууны арьс шир хэмжээ, чанараараа том үхрийнхээс дутуугүй. Малчид арьсыг элдэж, ачилга татлагын сур, ширэн эдлэл хийнэ. Үйлдвэрийн сайн чанарын хром хийдэг.

Хөөвөр хялгас: Нэг адуунаас дунджаар 420 гр дэл, 100 гр сүүл, 620гр хөөвөр авна. Эдгээрээс дэл, сүүлээс нь ахуйн хэрэглээний олс бэлтгэнэ.

Уналга эдэлгээ: Төв Азийн нүүдэлчид адууг бага наснаас сургаж эхэлнэ. Энэ нь гүү барьж, унага уяхаас эхлэн сургаж, эдэлгээнд бэлтгэнэ. Адууг унаж эдлэхээс гадна тэрэг чарганд хөллөж, тээвэрт хэрэглэнэ.

Морин спорт: Төв Азийн нүүдэлчид хэзээнээс адууг спортын чиглэлээр өргөн ашиглаж иржээ. Төв Азийн ард түмнүүдийн дунд морин уралдаан өргөн дэлгэрсэн байна. Тэдний дунд хурдан морь шинжих, уях, сойх арга ухаан, уламжлалт ёс заншил ихэд түгжээ⁵. Хурдан хүлгийн тухай ардын домог яриа, туульс өргөн тархсан байдаг. Хурдан морины шинжийг шинжих ард түмэн бүрт өвөрмөц онцлог байх боловч хурдан морины гадар, дотор, нууц гэсэн гурван шинжийг гсллоно. Уралдахаас гадна морь уургалах, булгиулах, бугуйлдах, морин дээрээс нум сум харвах, газраас дарцаг шүүрэх, саад хагайлгах, казах үндэстэнд “Көк бөри”, “Кыз куар” зэрэг морин тоглоомын төрөл байна.

Морины тоног хэрэглэл: адууг унаж эдлэхэд хазаар, чөдөр, логт, хударга,

эмээл, ташуур, хомуут, тэрэг, тэрэгний хэрэгсэл, хусуур сойз гэх мэт тоног хэрэгсэл байна. Энд хамгийн чухал зүйл бол эмээл юм. Эмээлийг Төв Азид хэдийнээс хэрэглэсэн нь тодорхой бус боловч хаданд эмээлтэй морин зургийг зурсан нь олон юм. Эмээл нь монгол, киргиз, казах, орос гэх мэт төрөлд хуваагдана. Казах эмээл гэхэд хийх технологи, зориулалтаас болж олон төрөл байдаг⁶.

Адууны үржил: Түүний хээл авах хугацаа 6-7 сар болно. Гүү 11 сар буюу 340 хоног хээлээ тээдэг буюу энэ хугацаандаа арчилгаа шаардана. Гүүг шүдлэн наснаас 13 нас хүртэл нийлүүлэгт оруулна. Зан авир номхог, дөлгөөн, үр төлөөр сайн удмын бараан хээр, хар, хүрэн зүсмийн азарга тавихыг эрхэмлэдэг бөгөөд азаргыг дэллэдэггүй. Азарга нь чоно зэргээс сүргээ хамгаалдаг.

Бэлчээр тэжээл: Төв Азид адууг голдуу бэлчээрээр малладаг ба байраар маллах хэсэг ч бий. Адуу бол ямар ч нутагт зохицдог, маллагаанд бага зардал шаарддаг онцлогтой. Малчид адуун сүргийг тухайн нутагтаа зохицуулан маллах нийтлэг арга нийтлэг арга технологийг өөрсдөө сонгоно.

Адууны нас, шүд: Нас гүйцсэн азарга, морь 40 шүдтэй, үүдэн шүд-12, соёо-4, араа-24 бол нас гүйцсэн гүү 36 шүдтэй, соёо бараг байхгүй. Төв Азийн нүүдэлчид малын шүдний гарц, элэгдлээр насыг нь тодорхойлсно. Монголчууд унага, даага, шүдлэн, үрээ, байдас, хязаалан, соёолон, хавчиг соёолон, гүйцмэл, дор зах гэхчлэн 1-8 насыг нэрлэнэ. Казахууд кулын, тай, кунан, бести, алты, жети, жуан, кари, лахса гэх зэргээр нэрлэнэ.

Адууны зүс: Адуу голдуу хээр, зээрд, хүрэн, бор, хонгор байх нь элбэг юм. Монгол адуу бол судлаачдын бичсэнээр үндсэн 16, давхар 160 зүс байна. Казах адуу бол Г.Грум-Гржималогийн бичсэнээр үндсэн 28 зүстэй юм⁷.

Адууны явдал: Адуу нь гэлдэргээ, шогшоо, хатираа, цогио, жороо гэсэн үндсэн явдалтай. Казахуудын дунд жороо морь ихээхэн өндөр үнэтэй байдаг.

Адуу ба ардын эмчилгээ: Адууны мах сүүг нь эмчилгээнд өргөн ашиглана. Адууны махыг нимгэн зүсэж, хугарсан ясыг бэхжүүлэхэд хэрэглэнэ. Адууны өөх төрөл бүрийн шархыг эдгээнэ. Адууны арьс нь битүү шархыг илааршуулахад, адууны дэлгүү нь хавдрыг буулгана. Айраг нь уушги, зүрх, судасны зэрэг өвчинд сайн эм болдог. Ялангуяа, саамыг нүүдэлчид өргөн хэрэглэнэ. Айрагны эмчилгээний талаар судалгаа хийгдэн, эмчилгээний сувилал Монгол Улс, Казахстанд олон ажиллаж байна. Мөн түүнчлэн казахын ардын эмчилгээнд адууг өргөн ашиглана. Өвчтөнг эмчлэхэд онцгой зүс, үүлдэр, насны адууг сонгон ашигладаг байна. Энэ тухай тодорхой жишээг Жанайдарова “Тенгрианство: мифы и легенды древных тюрков” номонд байдаг билээ.

Адуу ба хэл: Төв Азийн ард түмнүүдийн хэл адуу, түүний анатоми, ашиг шим, мах, сүү, арьс шир, уналга эдэлгээ, зан заншилтай холбоотой нэр томъёогоор нэн баялаг билээ. Тухайлбал, Казах хэлэнд адууны талаархи нэр томъёог Ш.Жанабилов судлан бичжээ. Үүнд адуун сүрэг, гүү, анатоми, унагалах, арчилгаа маллагаа, нас, саах, дэлний онцлог, сүүний гарц, зан авир, дэл сүүлний байдал, өвчин эмгэг, зүйр цэцэн үг гэх мэтээр судлан харуулжээ.⁸ Казах

хэлний хэлцийг И.Кенесбаев судалжээ⁹. Монгол хэлний хувьд Н.Доржготов , Ж.Лувсандорж \ нарын бүтээлд тусгалаа олжээ¹⁰.

Адуу ба тахин шүтлэг: Төв Азийн нүүдэлчдийн ахуй амьдралд адуу асар чухал үүрэг гүйцэтгэжээ. Тиймээс ч тэд адууг дээдлэн шүтдэг юм. МНТ болон туульсын зсхиолд хүлэг морьдын тухай олонтаа өгүүлдэг юм. Тухйалбал, Казахууд олон жил уналгад ашигласан морио өөрөө муулж, голгойн ясыг байшингийн дээвэр юм уу өндөр орчинд залж дээдэлнэ. Мөн малын дэл сүүлийг авахдаа тогтсон заншлыг дагах ба азаргыг дэллэдэггүй нь дэл сүүл шиг олон томтой болгох гэсэн санаа юм. Казахууд гүү барихад азаргын магнайд шар тос түрхэж, сүү сааль элбэг болохыг бэлгэднэ. Монголчууд айргийн тавын мориын дэлэнд сүү өргөж хүндэлнэ. Хурдан морины тоноглолыг хүндэлж, хулгайлахыг цээрлэнэ. Мөн казахад Ашамай хүүхдийг морь унуулж сургах, камшы /ташуур/, хурим найр, серне ат болон айрагны талаар олон тооны дагаж мөрдөх заншил байдаг юм.

Тэмээн сүрэг. Төв Азийн таван хошуу малын нэг нь тэмээ юм. Дэлхийд ховрын тоонд ордог тэмээ бол тэсвэртэй, ашиг шим сайтай, сүрлэг сайхан амьтан билээ.

Тэмээний үүсэл: Одоогоос олон арван сая жилийн тэртээ амьдарч байсан туулайн чинээ биетэй пропилопус өөрчлөгдсөөр нэг ба хоёр бөхт тэмээ үүсчээ. 5000 жилийн өмнөөс гэрийн амьтан болжээ. Төв Азийнхан мөн адил тэмээг маш эртнээс мал болгож ашиглаж иржээ. Төв Азид хоёр бөхт буюу бактариан тэмээ тархжээ. Төв Азид хоёр бөхт тэмээгээр Монгол Улс тэргүүлж байна. Казахстан 100000 гаруй тэмээтэй байна. Туркменстанд ганц бөхт тэмээ бий.

Тэмээний ашиг шим: Тэмээний ноос, мах, сүү, арьс ширийг авч ашиглахаас гадна уналга эдэлгээнд хэрэглэнэ. Тэмээний ноос онцгой дулаан, хөнгөн, бөх, нэг тэмээ 35-40 наслахдаа 300-480 кг ноос өгнө.

Мах: Тэмээ амьдын жингээр 400-800 кг хүрнэ. Махны амт чанар сайтай. Тэмээний өөх 55-60кг ба махны өөх 29-33 кг хүрнэ. Тэмээний өөх нь сайн чанарын саван, уруулын будаг, нүүрний гоёлын тос хийхэд ашиглана.

Сүү шим: Ингийг саах хугацаа дунджаар 528 хоног үргэлжилдэг өвөрмөц онцлогтой юм. Өдөрт 2-4 л сүү гарна. Нэг ингэ амьдралын туршид 6600-8000л сүү өгнө. Сүү нь удаан гашилдаг, өтгөрөх тусам амтлаг болно. Ингэний сүүнд глютаминий хүчил байх тул зарим өвчнийг анагаах чадалтай. Төв Азийнхан тэмээний сүүнээс шубат, чал, хоормог хийнэ. Төв Азийн тэмээний сүүний, бүтцийг нарийвчлан судалжээ¹¹. Мөн тэр зохиолд туркмен, казахуудын чал, шубат хийх технологийг харуулжээ.

Арьс шир: Арьс нь том, чанар сайтай учир хром эдлэл, гутал, хөхүүр, богц, суран эдлэл хийдэг нь түгээмэл юм.

Ачилга уналга: Төв Азийнхан тэмээг ачилга уналганд ашиглаж иржээ. Олон зууны туршид тэмээ нь тээврийн гол хэрэгсэл байсан боловч өнгөрсөн зуунаас хойш ач холбогдол нь буурчээ. 200 кг ачааг нуруундаа тээх ба 400-600 кг ачаатай тэрэг чирч 30-60 км явж чадна. Тэмээ уралдуулан шоу зохиодог

уламжлалтай юм.

Тэмээний үржил: Хоёр жилд нэг удаа ботголох ба хаврын урь орох үед ингэний нийлүүлэг явагдана. Нэг бууранд 20-30 ингэ гишгүүлэх ба 20 нас хүртэл ашиглана. Хээлээ 13 сар тээж, амьдрах хугацаандаа 10-11 удаа ботголдог байна.

Тэмээний хариулга, маллагаа: Тэмээн сүргийг эр, эм, сувай, хээлтэй гэх мэт суурилан, улирал, бэлчээрийн байдалд зохицуулан маллана. Баглуур, хамхуул, мууль, шарилж, шаваг, божмог, агь, бударгана, харгана гэх мэт ургамалтай газар бэлчээрлэнэ. Тэмээ маллахад тэмээчний мэдлэг чухал байдаг.

Тэмээний тоног хэрэгсэл: Эдлэхэд буйл, бурантаг, ногт, тушаа, халбар, тохом, хом, ороолт, бамбай, шат, тэрэг гэх мэт тоног орно.

Тэмээний нас шүд: Тэмээ 34 шүдтэй. 6 нь доод үүдэн шүд, 24 нь араа, 4 нь соёо болно. Төв Азийн нүүдэлчид тэмээг ботго, тором, буйлт, тайлаг, ингэ гэх мэт нас хүйсээр нь ялган нэрлэнэ. Тэмээний төрхийг гол төлөв бөхний нь аяс хэлбэрээр нэрлэнэ.

Тэмээ ба хэл: Төв Азийн ард түмнүүдийн хэлэнд тэмээтэй холбоотой нэр томъёо, зүйр цэцэн үг, хэлц гэх мэт арвин их байна. Тухайлбал, Казах хэлний тэмээний тухай нэр томъёо, хэлц үгийг дурдаж болох байна. Ш.Жанабилов номныхоо 45-79 хуудсанд энэ талаар дэлгэрэнгүй бичсэн билээ. Монгол хэлэнд мөн адил судлагджээ¹².

Тэмээ ба ардын эмчилгээ: Тэмээний сүү нь нэлээд олон өвчинд эм болно. Шубат, чал, хоормог нь уушигны өвчин болон сульдаа хүүхдэд тустай. Тэмээний ноос нь хавдсан газар, түлэгдсэн, нурууны өвчин, хугарсан ясны хавдарт сайн. Тэмээний уушги нь эмчилгээний чанартай юм.

Тэмээ ба тахин шүтэх заншил: Казахууд зассан буурны ар талын бөхөнд туулайн арьс өлгөнө. Энэ нь зассан буурыг чөтгөр шоолж, ард нь гарна, тэгээд туулайнаас чөтгөр айж халдахгүй гэсэн санаа юм. Шөнө тэмээ үргэвэл гэрээс гарахгүй, учир нь тэмээ өөрөөсөө том амьтнаас л айдаг хэмээн цээрлэнэ. Тэмээний толгойг “ноён мал” хэмээн үзэх учир идэхгүй, өндөр газар гаргаж дээдлэн тавина. Тэмээний ноосыг хулгайлан хяргахгүй. Ботгыг алж идэхгүй. Ботгод бурантаг хийхэд хамарт нь нохойн үсийг хийдэг нь ботго эсэн мэнд бойжиж, урт наслахыг бэлгэдэж, шар шувууны өд хатгаж хар хэл амнаас сэргийлнэ. Эрт үед хүндрэлтэй төллөж буй малыг “дэмийрсэн” гээд буурыг дэргэд нь авч ирж толгойг нь харуулан дом хийдэг байв.

Үхэр сүрэг. Төв Азид бол таван хошуу малын дунд үхэр сүрэг хүндтэй байр эзэлнэ. Мах сүү нь ихээхэн ашиг тусыг өгнө.

Үхрийн үүсэл: Сүүн тэжээлт, тугалмайт эвэртний язгуурт багтдаг, ац туруут, хивэгч амьтан юм. Манай тооллоос 10-аад мянган жилийн өмнө үхрийг гэрийн тэжээмэл болгожээ. Дэлхийд 400 гаруй үүлдрийн үхэр байна. Төв Азид казахын цагаан толгой, монгол үхэр, алатау, сарлаг, хайнаг болог эрлийзэжсэн үхэр тархжээ. Үхрийг мах-сүү, сүү-мах, махны чиглэлээр өсгөдөг.

Үхрийн ашиг шим, эдэлгээ маллагаа: Үхрээс авч байгаа бүтээгдэхүүн бол

сүү, мах, арьс юм. Үнээний сүүний гарц нь тэжээл, арчилгаа, үүлдэр угсаа, нас гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаална. Үхрийн мах бол хүнсний хамгийн үнэт зүйл. Үхрийн махны чанар нь үүлдэр, нас, хүйс, тарга хүч зэргээс шалтгаална. Махны калориллог чанар нь тарга тэвээрэг муутайд нь 1200 калори байдаг бол тарганд нь 3000 калори байдаг. Үхрийн шир бол үйлдвэрийн үнэт материал юм. Үхрийн эвэр туруу, цусаар цавуу, цусны гурил зарим төрлийн эмийн бодис хийдэг. Үхрийн маллагаа үндсэндээ нийтлэг түгээмэл байна.

Үхрийн тоноглол: Энэ нь ачаа зөөх, нүүж суухад үхрийн шард нуруу ачих, тэрэг хөллөнө. Энд тусгайлан бэлтгэсэн, үхэр тэрэг, тоноглол чухал юм.

Үхрийн нас, шүд: Шүд насыг нь шүдээр нь болон эврийн цагирагаар нь тодорхойлдог. 32 шүдтэй, үүнээс 8 нь үндсэн шүд юм. Насны дагуу тугал, бяруу, гуна, дөнж, шар гэх мэт нэрлэнэ.

Бэлчээр: Үхэр өвсийг хэлээрээ ороож иддэг тул агь, богууль, хиаг, ерхөг, таана, хөмөл, хазаар өвс, шаваг зэрэг ургамалтай бэлчээр тохиромжтой.

Үхэр ба хэл: Үхэр, түүний бие, зан, нас, шүд, өнгө, зан авир зэргийг илэрхийлсэн үгс арвин байна.¹³

Үхэр ба тахин шүтлэг: Казах үхрийн өвөг эцгийг Зенгибаба хэмээн үзэж, үхэр уснаас гарсан гэж төсөөлдөг. Үхэр сүүтэй байхыг эрхэмлэнэ. Заримдаа үхрийг тийм ч магтахгүй. Үхэр ихэрлэхийг муу зүйл хэмээн үзэж, хэн түрүүлж үзсэн хүн нь ихэр тугалын нэгийг алдаг заншил бий. Үхрийн бөөр, хөх, элгийг идэхгүй. Үхэрд үхрийн цус, сэвсийг үзүүлэхийг цээрлэнэ. Үхэр шөнө тугалбал аюулын дохио хэмээн үзнэ.

Үхэр ба ардын эмчилгээ: Үхрийн мах сүүг эмчилгээнд өргөн ашиглана. Хүйтнээс бслсон өвчинд үхрийн сүү өгнө. Мах нь хоолойны өвчинд, хөхүүл ханиаданд сайн.

Хонь: Төв Азид хонины аж ахуй их хөгжжээ. Хонин аж ахуй эдийн засгийн ач хэлбогдлоороо тэргүүн байр эзэлнэ.

Хонины үүсэл: Хонь маш эрт цагт гэрийн тэжээмэл мал болжээ. Хонь олон үүлдэр угсаатай¹⁴. Үүнээс шалтгаалан ашиг шим, ноос, мах, маллах арга зэрэг нь хоорондоо адилгүй. Бид энд Төв Азийн нэлээд тархсан казах¹⁵, монгол үүлдрийн¹⁶ хонины тухай өгүүлнэ. Хонины ашиг шим нь их, хонины үс, ноос, мах, сүү, арьс зэргийг ашиглана.

Хонины ноос: МТӨ 4500 жилийн өмнөөс нүүдэлчин айлууд хонин уртын ноос, ахраар гэрийн бүрээсний эсгий, ширдэг, тохом, урлалын бусад зүйл хийж байжээ. Хонины ноосноос цэмбэ, ноосон даавуу, хивс, малгай, цамц, гэрийн бүрээс, эсгий гэх мэт хийнэ.

Хонины мах: Төв Азид хонины махны нядалгааны гарц 54-56 хувь байна. Төв Азийнхан малынхаа мах, сүү, арьс ширийг ашиглах арга ухааны арвин туршлага хуримтлуулжээ. Тухайлбал, хонины махыг эвдэх, малын мах, яс зэргээр хүндэтгэл илэрхийлэх ёсоор арвин юм. Хамгийн хүндтэй хүндээ монголчууд хонины ууц чанаж тавьдаг бол казахууд хонины толгойг хамгийн эрхэм дээд чанартай гэж үнэлэн зочиндоо өгдөг юм. Казахуудад махны үе мөч

бүхэн нэртэй бөгөөд өөрийн хэрэглэх зориулалттай байна¹⁷.

Хонины сүү: Сүү нь тослог ихтэй. Төв Азийнхан хонио сааж, сүү авч, төрөл бүрийн хоол хүнс бэлтгэдэг уламжлалтай.

Хонины арьс: Төв Азийн нүүдэлчид хонь өвчих өвөрмөц технологитой. Тухайлбал, монголчууд өрлөж, казакууд хоолойг огтлон байж мал муулна. Эхлээд арьсыг тодорхой дэс дарааллаар яаран, шар мах оруулалгүй өвчинө. Өвчсөн арьсыг угааж, хатааж, давслан айраг, тараг түрхэн идээ оруулан элдэнэ. Элдсэн арьс нь бүтээгдэхүүн хийхэд бэлэн болдог.

Хонины үржил: Хонин сүргийн үржил нь хуцыг зөв сонгохоос эхэлнэ. Энд бие галбир, ноосны гарц, сүүлний янз, удам угсаа, өнгө зүс, арьс хөрсөөр нь шилж сонгоно. Хонийг хоёрдугаар сарын сүүлч, 3-р сарын эхээр хургалахаар бодож, хээлтүүлэг явуулах нь Төв Азид түгээмэл юм. Нэг хонь нэг жилд 2, 2 жилд-4, 3 жилд-8, 4 жилд-16, 5 жилд-32, 6 жилд-64, 7 жилд-128, 8 жилд-256, 9 жилд-512, 10 жилд-1024 хонь болж өсдөг юм.

Хонины бэлчээр: Хонины бэлчээр нь жилийн 4 улиралд төдгүй сар сар, өдөр өдөрт нь өөр байна. Энэ нь өвсний байдал, цаг уур, салхины чиглэл гэх мэт микроцаг уурын нөхцлөөс шалтгаална. Улирал болгонд хонь маллах технологи өөр өөр байна. Мөн угсаатан бүр, байгалийн бүс гэх мэт онцлогтой юм. Газрын гадаргад мал идэж болох ургамал, өвсний тоог эрдэмтэд 800 гэж үздэг. Тэдгээрээс нь хонь 520-ыг иддэг ба тэдгээрээс нь 91 төрлийн агь байдаг, үхэр тэдний зөвхөн 24, адуу 39-ыг нь иддэг бол хонь 46 төрлийг нь иддэг байна. Эндээс хонь бол уян хатан тэжээл гэж хаана бол хаана бэлчээрлэх боломжтой нь харагдана. Казахуудын уламжилт хонь маллах арга¹⁸ нь монголчуудтай төстэй билээ.

Хонины нас шүд: Хонийг монголчууд хурга, шүдлэн /эр/, төлөг /эм/, хязаалан, зусаг, соёолон гэх мэт, казакууд козы, тогты, тусах, хошхар гэх мэт нэрлэнэ. Хонь 32 шүдтэй, үүдэн шүд 8, араа 24. Нэг сартайд хурганы үүдэн шүд, 9 сартайд нэг, хоёрдугаар араа нь ялгарна. Голын 2 үүдэн шүд нь солигдохыг шүдлэн, дунд 2 үүдэн шүд нь солигдохыг хязаалан, захын шүд солигдохыг соёолон, шүд жигдрэхийг нас гүйцсэн гэнэ.

Хонь ба хэл: Төв Азийн нүүдэлчдийн хэлэнд хонь, түүнтэй холбоотой нэр томъёо нэн элбэг билээ. Үүлдэр угсаа, биеийн анатоми, хүйс, нас, зүс, саах, нийлүүлэг, ноос, эр, эм, хул, ирэг, хурга, зан авир, явдал, эр хонийг засах, им тамга, өвчин түүний эмчлэхтэй тэдгээр хэлний үгсийн сангийн томоохон хэсгийг эзэлнэ. Тухайлбал, Казах хэлэндэх нэр томъёог дурдаж болох юм¹⁹. Казах хэлээр хонины дагзанд 60, толгойд нь 500 нэр байгаа юм. Монгол²⁰, казах²¹ хэл нь хоньтой холбоотойг зүйр цэцэн үг, ерөөл гэх мэт нэн элбэг болно.

Хонь ба тахин шүтлэг: Казахууд хонины өвөг дээдэс нь Шопан Ата гэж нэрлэн хонь диваажингаас гарсан гэж үзнэ. Шөнө хонь майлахыг айх, аюулын шинж хэмээн төсөөлдөг. Өвчин зовлонгоос сэргийлэн хонийг тахиж, тахиулагч цээжээ үнэртүүлэн давс өгнө. Хүзүүнд хөгний хэсгийг зүүнэ. Тэр хонийг алж идэхгүй, ядуу зүдүү хүнд өгвөл тэр идэж болно. Тэр хонь өөрөө үхвэл сайн гэдэг бөгөөд тахигчийн зовлон зүдгүүрийг нимгэлсэн гэж үздэг. Хүмүүс баярлахдаа,

айхдаа, ямар нэгэн аюул тулгарахдаа, тэнгэрт залбиран юм чүсэхдээ хонь гаргаж, найр хийхийг “ахсарбас” гэдэг юм. Зориуд гаргах мал нь цагаан, цагаан халзан өнгөтэй байх нь аз жаргал, цэвэр ариун байхын бэлгэдэл юм²². Ирсэн зочинд, хүнд бэлэглэхэд хар зүсмийн хонь байхыг цээрлэнэ. Нядлах хонийг баруун талаас барих ба баяр ёслолд зориулсан хонины гурван хөлийг л бооно. Хонинд халдварт өвчин тусвал оршуулгын газар хонуулж, чонын арьсаар шөнө гурван удаа үргээнэ. Алсын замд явсан хүнд зориулан хургыг нэрлэдэг зэрэг олон заншил байна.

Хонь За ардын эмнэлэг: Хонины мах сүү нь өвчинг эмчлэх, өвчтөнийг тэнхрүүлэхэд өргөн ашиглагдана. Ялангуяа, нярайлсан эхэд “кэлжа” хэмээн хонь гаргаж, шинэ шөл уулгах ёсон байна.

Ямаа. Төв Азид ямаан сүрэг өргөн тархсан ба дийлэнх нь БНХАУ, Монгол Улсад байна. Ямааг гол нь ноолуур, сүүний чиглэлээр ашиглана. Ямааны ноолуур дэлхийн зах зээлд өндөр үнэлэгдэнэ.

Ямааны гарал үүсэл: Эрдэмтэд янгир ямаанаас гэрийн ямаа үүссэн гэж үздэг. Төв Азид МЭӨ 5700 жилд ямааг гэршүүлсэн байна. Ямаа нь олон үүлдэр угсаатай. Төв Азийн уугуул ямаа өөр хоорондоо болон янгир, Европын ямаатай эрлийжүүлж, ашиг шимийг дээшлүүлэх ажил хийжээ. Төв Азийн ямаа мах, сүү, ноолуурын чиглэлтэй юм. Гол ашиг шим нь ноолуур, хялгас, зүү, мах, арьс шир юм.

Ноолуур хялгас: Нэг ямаанаас 260 гр ноолуур, мөн төдий хэмжээний хялгас гарна. Ямааг нас, хүйс, цаг уурын байдлаас шалтгаалан харилцан адилгүй хугацаанд самнана. Урт, богино, хол, ойр шүдтэй 3-4 янзын самаар самнадаг.

Сүү: Ямааг өдөрт 1-2 удаа саахад саалийн хугацаанд нэг ямаанаас жилд дунджаар 50л хүртэл сүү ашиглана. Ямааны сүү нь үнээнийхтэй ойролцоо найрлагатай боловч тослог, уургаар баялаг, илчлэгээр давуу. Кальци, фосфор, витамин ихтэй учир хүний биед шим тэжээл болно.

Мах: Нэг ямаанаас 12-18 кг мах, 2-3 кг өөх авна. Хүний хоол тэжээл хамгийн гол үзүүлэлт болох уургаар баялаг.

Арьс: Төв Азийнхан ямааны арьсаар дулаан хувцас, эдлэл хийнэ.

Үржил төл: Ямаа үр төлөө өгч, үржилд тэнцэх нийт хугацаа 7-8 жил. Ишиг хүйтэнд тэсвэрлэхдээ муу, бээрэг учир нилээн дулаарсан үед төллүүлнэ.

Бэлчээр тэжээл: Төв Азийнхан ямаа бэлчээрлүүлэх өвөрмөц туршлагатай. Өдөрт дунджаар 9-16 цаг бэлчээрт байна. Агь, шувуун хөз, хөмөл, таана, гөгөд, мангир, хиаг, ерхөг, шарилж мэтийн өвс ургамал иднэ.

Ямааны нас шүд, зүс: Ямааг нас, хүйсээр ялган нэрлэнэ.

Ямаа За хэл: Ямааг мөн тал бүрээс нь нэрлэсэн нэр томъёо, уран үгс, зүйр цэцэн үг элбэг.²³

Ямаа ба тахин шүтлэг: Ямааны өвөг нь Шекшек Ата, бөгөөд ямааг хад чулуунаас бий болжээ гэж төсөөлдөг. Ямааг хүндэтгэх боловч бусад малын түвшинд авч үзэхгүй. Чөтгөр бол ямаанд дуртай, ямаан дүрстэй байна гэж үзнэ. Тэгээд шөнө ганц ямаа тааралдвал сэжиглэнэ. Нүүдэлчид зочноо

ямаагаар дайлахыг цээрлэнэ. Тавьтаргүй, тэсвэргүй явдлыг ямаатай зүйрлэнэ. Монголчууд сэрхийг тахиж, хүзүүнд угас уяж тавина. Малын хамгаалагч гэж үзнэ. Ойрдуудын бөхчүүд ямааны арьсаар зодог шуудаг хийж барилдана.

Ямаа ба ардын эмчилгээ: Ямааны өөхийг түлэгдсэн газар тавина. Ямааны сүүг хөхүүл ханиад, сульдаа хүүхдэд уулгана. Ямааны өөхийг халуунаар ханиадыг дарахад ууна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ В.М.Синицын. Центральная Азия.М.,1959. с.5-6

² Энциклопедия нового Китая. М.,1989.с.12

³ Дэлхийн улс төрийн зургийн бүрдлийн түүх, орчин үе. Улаанбаатар, 1999

⁴ Radloff.W.W.Die Haushede der Kirdisenl.Zeithschirift der Ethnofide., Ber-ti1871.Bd.,s:285-313

⁵ Казахын үндэстний хоол хүнс. А., 1977.т.33-35

⁶ А.Баярмагнай. Монголчуудын хурдан морь уях соёл, түүхэн уламжлал. УБ,1997 “Традиции предков-бесценное сокровище” А.1988.с.68-96-д казахуудын хурдан морь уях соёл, түүхэн уламжлалыг өгүүлжээ.

⁷ “Традиции предков-бесценное сокровище” А.1988 с.96-113. “БНМАУ-ын угсаатны зүй” Боть-1.,УБ.1987 Боть-2., УБ.1996 Боть-3. УБ.1996.

⁸ Г.Грум-Гржимайло. Описание путешествия в Западный Китай.Т.1 В доль Восточного Тяньшанья.с.430

⁹ Жанабилов Казакын мал атаулары А.1982 т.6-44

¹⁰ К.С.Кенесбаев.Фразологический словарь казахского языка.А.,1977. б.514-518.

¹¹ Ж.Лувсандорж “Малчны эрдэм” УБ.1986 Н.Доржготов “Англи-Монгол, Монгол-Англи аж ахуйн дүймэн.УБ.,1999

¹² Кумыс и Шубат. А., 1980. с.171-197

¹³ Ж.Лувсандорж “Малчны эрдэм” УБ.1986. т.157-189

¹⁴ Ж.Лувсандорж “Малчны эрдэм” УБ.1986.Жанабилов Казахша мал атаулары А.1982 т.80-97

¹⁵ Ш.Жанабилов Казахша мал атаулары А.1982 т.98-103

¹⁶ Мөн тэнд

¹⁷ Хүүхэд залуучуудын нэвтэрхий толь.УБ.,1983.т.121-22

¹⁸ Х.Досымбек.Монголын казахуудын уламжилт хоол хүнс.А.,1996.т.1-21

¹⁹ С.Калиев. М.Оразаев. М.Смаилова. Обычай и традиции казахского народа.А.,1994.б.88-99

²⁰ Ш.Жанабилов Казахша мал атаулары А.1982 т.98-130

²¹ Ж.Лувсандорж “Малчны эрдэм” УБ.1986

²² К.С.Кенесбаев.Фразологический словарь казахского языка.А.,1977. б.514-518.

²³ К.Бикумар.Монголиядагы казахтардын салт-дастурлери.Ө.1995.б.11-136